



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№109 /553/

2023.07.17

Цаг үе, үйл явдал

ЕСӨН ХӨЛТ ЦАГААН ТУГИЙГ ТӨВ ЦЭНГЭЛДЭХЭЭС ТӨРИЙН ОРДОН РУУ ЗАЛЛАА



Тулгар төрийн 2232 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 817 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112 жил, Ардын хувьсгалын 102 жил жилийн ой, Үндэсний их баяр наадмыг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хааж үг хэлсний дараа Есөн хөлт цагаан тугийг Төв цэнгэлдэхээс гаргах Төрийн ордон руу залах ёслолын ажиллагаа зохион байгуулагдлаа.

Монгол төрийн мандан бадрахын бэлгэдэл болсон Есөн хөлт цагаан тугийг торгон цэргүүд жилдээ нэг удаа Төв цэнгэлдэхэд залж, цэнгүүлдэг уламжлалтай билээ.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 18	🌧️ 9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	🌧️ 25

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,427	3,433
EUR 🇪🇺	3,740	3,756
CNY 🇨🇳	476	478
RUB 🇷🇺	38.70	40.10
JPY 🇯🇵	23	24.10
KRW 🇰🇷	2.62	2.63

ЗУРХАЙ

2023.07.17 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 30

ЗУНЫ ДУНД ШАР МОРЬ САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ УЛААН ХУЛГАНА ӨДӨР

ҮС ЗАСУУЛБАЛ:
Эрлэг лугаа учирна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.10-20.46
БАРИЛДЛАГА:
Үл зохилдох
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Тийн мэдэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

ТӨРИЙНХӨӨ НААДАМД 15 ДАХЬ ЖИЛДЭЭ ОРОЛЦСОН ЗАГАЛ



сайн, үргэж мэдэхгүй, жагсаалч, эзэндээ ээлтэй, Төрийн тугийг залах, цэнгүүлэхэд гаршиж, наадам бүрээр төрийн хонжинтойгоо омогшил, бахархалтайгаар наадамчин олныхоо өмнө гарч ирдэг нь яахын аргагүй төрийн хүлэг гэдгийг нь нотлох биз ээ.

Ахмад Д.БОЛОР



Төрийн хонжны хүлэглэсэн энэхүү загал нь төрийнхөө наадамд 15 дахь жилдээ оролцов. Тэтгэвэрт гарах хугацаа нь болсон хэдий ч ижил сүрэгтэй хайртай, дайчдадаа дассан сэтгэл нь төрийн наадмын зүг чиглүүлсээр л байдаг ажээ. Анх энэхүү бор морийг Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагчаар ажиллаж байсан хурандаа Ч.Баярсайхан Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын ажилсаг, хөдөлмөрчөөрөө нутагтаа алдартай нэгэн малчны хотоос өөрийн биеэр очиж, нүдэлж авч байсан түүхтэй. Тэр цагаас хойш тасралтгүйгээр 15 дахь жилдээ Төрийн их наадамдаа оролцсон юм.

Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн үе үеийн захирагч нар төрийн хонжин хэмээх эрхэм үүрэг хүлээдэг бөгөөд хурандаа Ч.Баярсайхан гурван жил, хурандаа Л.Батболд долоон жил, хурандаа Ж.Мөнхбаяр гурван жил, хурандаа М.Болдбаатар хоёр дахь жилдээ хүлээлгэсэн нь энэ. Уг нь өнгөрсөн жилийн наадам буюу Ардын хувьсгалын 100, 101 жилийн их баяртаа сүүлийн удаа үүрэг гүйцэтгүүлээд тэтгэвэрт гаргана гэж байсан ч энэ жил ижил сүргээсээ огтхон ч холдож чадаагүй гэхээр дэндүү хайрлам. Хэдий нас өндөр болсон ч гүйцэтгэл

200 ГАРУЙ МЭРГЭЖЛИЙН АХЛАГЧ НЭГТГЭЛ, АНГИУДАД ТОМИЛОГДЛОО



Өнөөдөр Хуурай замын цэргийн командлалын ахлагчийн хөгжлийн төвийн дэргэдэх мэргэжлийн ахлагч бэлтгэх сургалтын төвийн 200 гаруй сонсогч Зэвсэгт Хүчний цөм болсон ахлагчийн албанд элсэн орлоо. Мэргэжлийн ахлагч бэлтгэх сургалт нь хоёр сарын хугацаанд түргэвчилсэн хичээлийн хөтөлбөрөөр Хуурай замын цэргийн командлалын материаллаг баазыг түшиглэн зохион байгуулагдсан юм.Тус сургалтаар нийт 215 мэргэжлийн ахлагч бэлтгэгдсэн бөгөөд үүнээс ЗХЖШ-ын харьяа ангиудад 68 цэргийн алба хаагч, бусад бүрэлдэхүүн Хуурай замын цэргийн командлалын харьяа ангиудад тус тус томилогдлоо.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,899,782

Эдгэрсэн

Нийт: 663,380,926

Нас барсан

Нийт: 6,903,492

Цахим шууданд

Ахлагч Б.Мөнхзаяа: УРМЫН ҮГЭЭР МЯЛААЖ БАЙГАА МОНГОЛЧУУДДАА БАЯРЛАЛАА



Монгол Улсын марафонч охин Азийн аварга шалгаруулах хөнгөн атлетикийн тэмцээний 10 мянган метрийн зайд хүрэл медаль хүртэж, Монгол Улсын рекордыг шинэчлэн тогтоолоо. Энэ амжилт бол Азийн аварга шалгаруулах хөнгөн атлетикийн тэмцээний задгай зайн төрөлдөө авсан Монгол Улсын анхны медаль билээ. Түүний олон жилийн хүч хөдөлмөрөөр олдсон энэхүү амжилтад иргэд ихэд бахдан "Дорнын их талын сүрэг олон зээр шигээ гүйдэг яахын аргагүй дэлхийн марафонч байна" хэмээн баяр хүргэсээр байна. Үндэсний шигшээ багийн тамирчин, Зэвсэгт хүчний "Алдар" спорт хороо, Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн алба хаагч, ОУХМ, ахлагч Баярцогтын Мөнхзаяатай цахимаар холбогдож сэтгэгдлийг нь хуваалцлаа.

-Танд баяр хүргэе, үнэхээр сайхан мэдээ байлаа ...

-Маш их баярлалаа. Тайландын нийслэлийн Бангкок хотноо долоодугаар сарын 12-16-ны өдрүүдэд Азийн аварга шалгаруулах хөнгөн атлетикийн 25 дахь удаагийн тэмцээний эмэгтэйчүүдийн 10 км буюу 10 мянган метрийн төрөлд оролцоод 33:24:79 цагийн амжилтаар хүрэл медаль хүртлээ. Медаль хүртээд зогсохгүй өөрийнхөө 2014 онд БНСУ-ын Инчон хотод зохион байгуулагдсан Азийн аварга шалгаруулах хөнгөн атлетикийн тэмцээнээр шинэчилсэн Монгол Улсын рекорд амжилтыг дахин 7 секундээр урагшлуулж чадлаа. Анх энэ амжилтыг манай улсын шилдэг марафонч Л.Отгонбаяр эгч эзэмшдэг байсан бол 2014, 2023 онуудад тус тус миний бие дахин шинэчилсэн гэсэн үг.

-Тэмцээнийхээ талаар тодотгохгүй юу, өрсөлдөгч нар мэдээж хүчтэй байсан байх ...

-Тэгэлгүй яах вэ. Энэ удаагийн тэмцээн Хөнгөн атлетикийн Азийн холбооных нь 50 жилийн ойтой давхцаж буйгаараа онцлог. Орон орны хамгийн шилдэг гэсэн хөнгөн атлетикийн тамирчин оролцож байна. 10 мянган метрийн зайд гэхэд дэлхийн 11 орны тамирчинтай өрсөлдсөн ба тэдний олонх нь замаа ердөө 30-32 минутад туулдаг амжилт тогтоосон өндөр зэрэглэлийн хүчтэй залуус. Эхний нэг, хоёрдугаарт байрт шалгарсан Японы тамирчин гэхэд 31, 32 минут, Казахстаны нэрийн өмнөөс оролцсон Кенийн тамирчин гэхэд 30.17 минутын амжилттай. Харин тэмцээний өдөр аз од минь гийж, бас бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилт өндөр байсны хүчинд дэлхийн шилдэг тамирчдыг ардаа орхиж чадсандаа баяртай байна.

-Та бүр эхний 6000 метрийн тойрогтоо өнгөлж байсан шүү дээ...

-Гараанаас гараад таван тойрог яваад уралдааны явцыг том дэлгэцээр харахад миний бие Японы хоёр тамирчны хамт тэргүүнд нь гүйж байсан. Үүнээсээ маш их урам зориг авч, түүрүүлэх боломж надад байна гэж итгэсэн. Тэр эрчээрээ ч амжилттай гүйсэн. Харамсалтай нь барианаас ердөө 2000 метрийн өмнө Японы

тамирчинд гүйцэгдсэн. Тайланд нь халуун дулаан уур амьсгалтай учраас гүйх тусам бүгчим болж байсан нь үүнд бас нөлөөлсөн байх. Эх орондоо хүйтэн сэрүүн нөхцөлд гүйгээд сурчихсан, халуун байсан ч сэвэлцсэн салхитай бол энд өдөртөө 30 хэмээс буурдаггүй юм байна. Гэхдээ хувьтай хүн хур борооноор гэдэгчлэн уралдааны өмнөхөн бороо орсон нь надад тааламжтай байлаа.

-Эхний хоёр байраас ердөө 25 болон 6 секунднээр зөрүүтэй нь 10 км-ын замд хол зөрүү биш гэдгийг дэлхийн хэвлэлүүдээр онцолсон байсан ...

-Баярлалаа. Бэлтгэл сургалт болоод улсын аваргын үеэр голчлон 34 минутын амжилттай гүйдэг байсан, харин Тайландад ирээд хэдий цаг агаарын хувьд халуун бүгчим байсан ч өөрийгөө бүрэн дайчилж, 2014 онд тогтоосон рекорд амжилтаа дахин шинэчилсэндээ баяртай байна.

-Бариад орж ирэхэд юу бодогдож байв?

-Тэргүүлж гүйж байсан болохоор "Надад аварга болох боломж байсан шүү дээ" гэсэн өөртөө бага зэргийн гомдолтой ч гэх юм уу тийм байсан. Шагналыг гардуулах ёслолын үеэр ч гэсэн төрийнхөө дууллыг эгшиглүүлсэн бол монголчууд минь ямар их баярлах байсан бол гэж бодогдоод л. Гэхдээ олон жилийн хүч хөдөлмөрөө амжилтын мэдээгээр өнгөлсөндөө баяртай байна. Үүнд дасгалжуулагч багш, миний хань, ОУХМ Б.Доржпалам, Х.Уянга багш болоод "Алдар" спорт хороо, Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хамт олон, хайртай гэр бүл, Дорнод нутгийн минь зон олон, найз нөхөд, спорт дэмжигчдийн итгэл найдвар, урам зориг намайг хурцалж, энэ амжилтыг гаргахад нөлөөлснийг онцлох учиртай.

-Манай улсаас хэдэн тамирчин оролцож байгаа юм бэ?

-Монгол Улсаас миний бие болон "Алдар" спорт хорооны тамирчин ОУХМ Б.Солонго, Д.Мягмарсүрэн, Хилийн цэргийн 0208 дугаар анги, "Хилчин" спорт хорооны тамирчин, ОУХМ Д.Гантулга гээд дөрвөн тамирчин оролцож, бидний удирдан чиглүүлэгч багшаар Үндэсний шигшээ багийн дасгалжуулагч ОУХМ Б.Доржпалам, Х.Уянга нар ажиллаж байна. Манай тамирчинд тэмцээндээ амжилт дүүрэн байна. ОУХМ Д.Гантулга 10 метрийн эрэгтэйчүүдийн төрөлд зургаадугаар байрт шалгарч, Б.Солонго, Д.Мягмарсүрэн нар зарим зайд хувийнхаа амжилтыг эвдсэн бөгөөд бидэнд 7 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд ч үргэлжлүүлэн оролцох гүйлтийн төрлүүд хүлээж байна.

Би гэхэд 7 дугаар сарын 16-ны өдөр 5000 метрийн зайд уралдана. Ямар ч байсан эх орныхоо нэрийг дахин зарлуулахын төлөө хичээх болно оо.

-Та бүхэндээ өндөр амжилт хүсье, эргээд баяртай уулзъя...

-Биднийг дэмжиж байгаа монголчууддаа маш их баярлалаа. Та бүхний сайхан сэтгэгдэл, урмын үг биднийг их хурцалж байгаа шүү.

Ахмад Д.БОЛОР

"АЛДАР"-ЫН БӨХЧҮҮД ТӨРИЙН ИХ НААДАМДАА ӨНГӨЛЛӨӨ



Тулгар төрийн 2232, Их Монгол Улс байгуулагдсаны 817, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жилийн ойн Үндэсний их баяр наадамдаа алдартнуудыг төрүүлдэг, хурандаа Г.Өсөхбаяр даргатай Батлан хамгаалах яамны харьяа "Алдар" спорт хорооныхон амжилтын боц дүүрэн оролцлоо. Хүчит бөхийн барилдаанд "Алдар" спорт хорооны үндэсний спортын албаны үндэсний бөхийн тамирчин, улсын гарди, дэд ахлагч М.Бадарч 9 даван түрүүлж "Улсын арслан" цол, мөн тус албаны тамирчин улсын харцага, энгийн Ц.Бямба-Отгон 8 даван үзүүлж "Улсын гарди" цол хүртлээ.

"Алдар" спорт хороо болон "Бага баян-Энхийн төлөө" цогцолборын бөх, аймгийн хурц арслан, энгийн С.Сүхбат 6 давж дунд шөвөгт шалгарч "Улсын харцага" цол, "Алдар" спорт хороо, Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн бөх аймгийн арслан, энгийн Г.Ганхуяг 6 давж "Улсын харцага" цол хүртсэн бахдам амжилт үзүүллээ.

Улсын арслан, дэслэгч Б.Орхонбаяр, улсын харцага, ахлагч

Ш.Пүрэвгарьд нар 5 даван шөвгөрч "Өсөх идэр" чимэг, улсын начин, ахлах дэслэгч Э.Даш 5 даван цолоо баталж "Өсөх идэр" чимэг тус тус хүртсэн гээд "Алдар"-ынхан уламжлал ёсоор алдраа дуурсгаж, алдар цолоо ахиулж, баталж, цол чимэг нэмж чадлаа.

Үүний зэрэгцээ өсвөр бөхчүүдийн барилдаанд "Алдар" спорт хорооны үндэсний бөхийн дугуйлангийн өсвөрийн бөхчүүд болох Өмнөговь аймгийн Ноён сумын харьяат сумын начин Отгонбаатарын Сумъяабазар, Говь-Алтай аймгийн Чандмань сумын харьяат Бат-Өлзийн Ганбаатар нар их шөвгийн дөрөвт шалгарч үлдсэн юм.

Хүчит бөхийн барилдаанаас гадна үндэсний шагайн харваагаар Монгол Улсын Үлэмж дархан мэргэн, спортын мастер С.Ямааранз ахлагчтай "Алдар" спорт хорооны баг гутгаар байрт шалгарсан нь баяр дээр баяр нэмэв.

"Алдар" спорт хорооны Үндэсний спортын албаны дарга, улсын харцага, дэд хурандаа Т.ӨСӨХ-ИРЭЭДҮЙ

ОЮУТАН ЦЭРГҮҮДИЙН АР ГЭРИЙН ТӨЛӨӨЛӨЛ ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЛЭЭ



Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын материаллаг баазыг түшиглэн явагдаж байгаа "Оюутан цэрэг" сургалтын нээлттэй хаалганы өдөрлөг 7 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан билээ. Зэвсэгт хүчний 327, 330 дугаар ангийнхан хоёр дахь удаагийн "Оюутан цэргийн нээлттэй өдөрлөг"-өөр байлдагч нарынхаа сурсан цэргийн эрдмээс толилуулахын зэрэгцээ урилгаар хүрэлцэн ирсэн ар гэрийнхний дунд уралдаан тэмцээн зохион байгуулж, иргэн-цэргийн харилцааг улам бэхжүүлэв. Зэвсэгт хүчний 327 дугаар ангийнхан ар гэрийнхний нь дунд автоматын задаргаа, угсрах уралдааныг явуулахад байлдагч

С.Чинтөсгийн аав Д.Сүхбаатар, байлдагч М.Сүхсайханы аав Н.Мөнхсайхан, байлдагч Л.Тэмүүлэнгийн ах Л.Наранхүү нар шалгарч, шагнагдлаа.

Мөн Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Б.Чинзориг хүрэлцэн ирсэн эцэг эхчүүдэд мэндчилгээ дэвшүүлж, эрчимжүүлсэн сургалтаар оюутан цэргүүд хэрхэн шамдан суралцаж, цэргийн эрдмийг эзэмшиж байгаа талаар энгийн яриа өрнүүлж, албаа үлгэр жишээ хааж байгаа дөрвөн байлдагчид дэд түрүүч, түрүүч олгогдсоныг гардуулан өгсөн юм.



Гэрэл зураг түүх өгүүлнэ



ХОЛБООЧИН ДАЙЧДЫН БЭСРЭГ НААДМААР...